**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Наранмандал өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БНА-2026/008/НА-СТА-ОНӨҮГ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2026.03.15 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Нарангэрэл<br>Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**Нэг.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 3

**Хоёр. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 5

**2.1 Төлбөрийн акт** ..... 5

**2.2 Албан шаардлага** ..... 6

**2.3 Зөвлөмж** ..... 6

**Гурав. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 7

**Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан** байдал ба **санал дүгнэлтийн талаарх мэдээлэл** ..... 7

## Нэг.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | БАЛАНСЫН ЗҮЙЛ | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | 2024оны 12-р сарын 31 | 2025 оны 12 сарын 31 |
| А | Б | 1 | 2 |
| 1 | **ХӨРӨНГӨ** | **556,653,477.19** | **420,861,789.20** |
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 732,147.43 | 18,848,698.60 |
| 1.1.2 | Бэлэн мөнгө | | |
| 1.1.3 | Татвар, ЭМД-ийн авлага | 114,867,682.51 | 6,315,690.30 |
| 1.1.4 | Бусад авлага | 277,500.00 | 277,500.00 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| 1.1.6 | Бараа материал | 43,130,244.00 | 36,594,782.90 |
| | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **159,007,573.94** | **62,036,671.80** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 388,139,403.25 | 350,984,867.40 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 9,506,500.00 | 7,840,250.00 |
| 1.2.10 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **397,645,903.25** | **358,825,117.40** |
| 1.3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **556,653,477.19** | **420,861,789.20** |
| 2 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | **599,783,721.19** | **457,456,572.10** |
| 2.1 | **ӨР ТӨЛБӨР** | **221,172.00** | **0.00** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 221,172.00 | |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **221,172.00** | **0.00** |
| **2.1.2.10** | **Өр төлбөрийн нийт дүн** | **221,172.00** | **0.00** |
| 2.3 | **2. Эзэмшигчийн өмч** | **381,044,923.13** | **381,445,923.13** |
| 2.3.1 | Өмч: -төрийн | 381,044,923.13 | 381,445,923.13 |
| 2.3.8 | Эздийн өмч бусад хэсэг | 6,174,000.00 | 6,174,000.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг: | 169,213,382.06 | 33,241,866.07 |
| 2.3.11 | **Эздийн өмчийн дүн** | 556,432,305.19 | 420,861,789.20 |
| 2.4 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **556,653,477.19** | **420,861,789.20** |

### 1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024оны12сарын31 | 2025оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | 893,286,676.77 | 628,616,863.27 |
| 2 | Борлуулалтын өртөг | | |
| 3 | **Нийт ашиг /алдагдал/** | | |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүний орлого | | |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | | |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | | |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 864,692,568.59 | 764,588,379.26 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | | |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | | |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | 28,594,108.18 | -135,971,515.99 |
| 19 | Орлогын татварын зардал | | |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | 28,594,108.18 | -135,971,515.99 |
| 24 | **Орлогын нийт дүн** | 28,594,108.18 | -135,971,515.99 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/ | | |

## 1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2024оны 12 сарын 31 | 2025 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1. | Мөнгөн орлогын дүн (+) | **855,144,290.26** | **756,110,603.48** |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 415,217,625.00 | 184,838,200.00 |
| | Татаас, санхүүжилтийн орлого | 419,813,826.45 | 421,214,439.60 |
| | Бусад мөнгөн орлого | 20,112,838.81 | 150,057,963.88 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **838,479,553.93** | **730,565,052.31** |
| | Ажилчдад төлсөн | 360,554,747.00 | 333,341,661.00 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 116,590,289.00 | 105,592,902.68 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 205,402,325.00 | 63,877,802.50 |
| | Ашиглалтын зардалд төлсөн /холбоо, бичиг хэргийн зардал/ | 28,205,750.04 | 48,219,258.00 |
| | Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 6,921,000.00 | 8,276,900.00 |
| | Хүүний төлбөрт төлсөн | | |
| | Даатгалын байгууллагад төлсөн | 124,250.00 | 228,200.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 120,681,192.89 | 171,028,328.13 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **630,736.33** | **18,116,551.17** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 16,034,000.00 | 7,429,000.00 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө | 16,034,000.00 | 7,429,000.00 |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | | |
| **3.3** | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **630,736.33** | **-18,116,551.17** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **101,411.10** | **732,147.43** |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **732,147.43** | **18,848,698.60** |

## 1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Эзний өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12 сарын 31 үлдэгдэл** | **331,249,197.73** | **6,174,000** | **140,619,273.88** | **478,042,471.61** |
| **Залруулсан үлдэгдэл** | | | | **0.00** |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | 28,594,108.18 | **28,594,108.18** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | **0.00** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 49,795,725.40 | | | **49,795,725.40** |
| **2024 оны 12 сарын 31 үлдэгдэл** | **381,044,923.13** | **6,174,000** | **169,213,382.06** | **556,432,305.19** |
| **Залруулсан үлдэгдэл** | | | | **0.00** |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | -135,971,515.99 | **-135,971,515.99** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | **0.00** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 401,000.00 | | | **401,000.00** |
| **2025 оны 12 сарын 31 үлдэгдэл** | **381,445,923.13** | **6,174,000** | **33,241,866.07** | **420,861,789.20** |

## Хоёр. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 150,301.3 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тус байгууллага нь худалдан авсан 150,301.3 мянга, зарцуулсан 156,836.7 мянган төгрөгийн бараа материалын тайланг гаргаагүй байгаа нь НББОУС-2 Бараа материал, мөн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 20,906.5 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс 3,392.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 15,953.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,560.0 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 2.1 Төлбөрийн акт

2.1.1 Тус байгууллагын дарга нь өөртөө шийдвэр гарган 3,392.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл болон урамшуулал авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Хууль зөрчиж шийдвэрийн дагуу олгосон 3,392.6 мянган төгрөгийг байгууллагын даргаар буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

**2.2 Албан шаардлага**

2.2.1 Тус байгууллага нь эрүүл мэндийн даатгалаар санхүүжсэн тусламж үйлчилгээний урамшуулал 13,904.3 мянга, Монгол улсад өрхийн эмнэлэг үүсэж хөгжсөний 25 жилийн ойн спортын тэмцээн уралдаан, ур чадварын тэмцээнд зориулж 2,049.6 мянга, нийт 15,953.9 төгрөгийг шийдвэргүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Цаашид хөрөнгө зарцуулахдаа байгууллагын даргын шийдвэрээр зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

**2.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт 1*</u>: Ажилчдын цалингаас хамтын сангийн 1,560.0 мянган төгрөгийн суутгасан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

<u>*Өгсөн зөвлөмж*</u>: Цаашид ажилчдын цалингаас хуульд зааснаас бусад хэлбэрээр суутгал хийдэг байдлыг таслан зогсоож зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Гурав. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тус байгууллага нь худалдан авсан 150,301.3 мянга, зарцуулсан 156,836.7 мянган төгрөгийн бараа материалын тайланг гаргаагүй байна. | 1 | 150,301.3 | 1 | 150,301.3 | | | 1 | 150,301.3 | | |
| Дүн | **1** | **150,301.3** | **1** | **150,301.3** | | | **1** | **150,301.3** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тус байгууллагын дарга нь өөртөө шийдвэр гарган 3,392.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл болон урамшуулал авсан байна. | 1 | 3,392.6 | 1 | 3,392.6 | | | | |
| Тус байгууллага нь эрүүл мэндийн даатгалаар санхүүжсэн тусламж үйлчилгээний урамшуулал 13,904.3 мянга, Монгол улсад өрхийн эмнэлэг үүсэж хөгжсөний 25 жилийн ойн спортын тэмцээн уралдаан, ур чадварын тэмцээнд зориулж 2,049.6 мянга, нийт 15,953.9 төгрөгийг шийдвэргүйгээр зарцуулсан байна. | 1 | 15,953.9 | | | 1 | 15,953.9 | | |
| Ажилчдын цалингаас хамтын сангийн 1,560.0 мянган төгрөгийн суутгасан байна. | 1 | 1,560.0 | | | | | 1 | 1,560.0 |
| **Нийт дүн** | **3** | **20,906.5** | **1** | **3,392.6** | **1** | **3,392.6** | **1** | **1,560.0** |

## Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ТШЗ | | | 1 | | | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | | | **1** | | | | | |

------------oOo-------------